


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛД НЭР ДЭВШИХ МАЯГТЫН ЗАГВАР

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.



Хуульд заасан шаардлага: Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан нийтлэг шаардлагаас гадна Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасан дараах шаардлагыг хангасан байна:

28.2.1. 45 нас хүрсэн байх;

28.2.2. эдийн засаг, санхүү, эсхүл хууль зүйн чиглэлээр дээд боловсролын зэрэгтэй байх;

28.2.3. төрийн албаны эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан байх;

28.2.4. сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байх;

28.2.5. Монгол Улсын Ерөнхий аудиторов бүрэн эрхэд харшлах ажил, албан тушаал давхар эрхэлдэггүй, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагад ашиг сонирхлын зөрчилгүй байх.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА, ТАВИХ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр: Сандаг Ургийн овог: Уран дархан Нэр: Магнайсүрэн Хүйс: Эр Төрсөн он: 1975.03.28 Төрсөн газар: Говь-Алтай аймгийн Жаргалан сум Иргэний харьяалал: Монгол Улс Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Намуун төгөл хотхон, 2в тоот
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал Монгол Улсын Ерөнхий Аудитор
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх

	/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/ “Тийм”			
1.4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. /сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/ 1. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургууль: “Хууль зүйн магистр”; 2. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн дээд сургууль: “Эрх зүйч мэргэжлээр бакалавр”.			
1.5	Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг “Үгүй”			
1.6	Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй талаарх нотлох баримтыг хавсаргана. “Үгүй”			
1.7	Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана. “Үгүй”			
1.8	Эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Төрийн албаны эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан болохыг нотлох баримтыг хавсаргана. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч /эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.			
	“Улаанбаатар Эрдэм” дээд сургууль	Багш, Тэнхимийн эрхлэгч	1997	1999
	Улсын Их Хурлын Тамгын газар	УИХ-ын гишүүний туслах	1999	2000
	Улсын Их Хурлын Тамгын газар	Зөвлөх	2000	2005
	Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар	Тамгын газрын дарга	2005	2006
	Хүнс, хөдөө аж ахуйн яам	Сайдын зөвлөх	2006	2007
	Сангийн яам	Газрын дарга	2007	2008
	Улсын Их Хурлын Тамгын газар	Тамгын газрын Нарийн бичгийн дарга	2008	2013

	Хөдөлмөрийн яам	Төрийн нарийн бичгийн дарга	2015	2015
	Барилга, хот байгуулалтын яам	Төрийн нарийн бичгийн дарга	2015	2023
	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Төрийн нарийн бичгийн дарга	2023	2024
1.9	Ашиг сонирхлын зөрчил Монгол Улсын Ерөнхий аудиторын бүрэн эрхэд харшлах ажил, албан тушаал давхар эрхэлдэг эсэх болон ашиг сонирхлын зөрчилтэй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар ажил, албан тушаал, ямар хугацаанд эрхэлж байгаа талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i> “Үгүй”			
1.10	Мэргэжлийн болон төрийн бус байгууллагын гишүүнчлэлийн талаар Сүүлийн хоёр жил ямар мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</i> 1. Монголын морин спорт, уяачдын холбооны Тэргүүлэгч гишүүн, Говь-Алтай аймгийн Морин спорт, уяачдын холбооны тэргүүн; 2. Говь-Алтай аймгийн Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн Тэргүүлэгч гишүүн, Жаргалан сумын Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн тэргүүн.			
1.11	Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал Сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын удирдах болон гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан болон улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан эсэхийг бичих. <i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i> “Үгүй”			

1.13	Мэргэжлийн ёс зүйн талаар Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх. <i>/тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i> “Үгүй”
1.14	Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол -Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ. - “Монгол Улсын Үндсэн хуулийн үгийн сангийн товчоо” эмхтгэл. Улаанбаатар хот, 2005 он. УИХТГ /хамтарсан/; - Улсын Их Хурлын Тамгын газар, Төрийн нарийн бичгийн даргаар ажилласан яамдын хагас, бүтэн жилийн тайлан, холбогдох баримт бичгүүд; - Ахалсан зөвлөл, салбар зөвлөл, хорооны тайлан, холбогдох баримт бичгүүд. -Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ. А. Хариуцаж батлуулсан томоохон хуулиуд: - Монгол Улсын Их Хурлын тухай хууль; - Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль; - Монгол Улсын Төрийн ордны тухай хууль; - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль; - Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч авах тухай хууль; - Шуудангийн тухай хууль; - Үнэт цаасны зах зээлийн тухай хууль; - Газрын тухай хууль; - Газрын төлбөрийн тухай хууль; - Тариалангийн тухай хууль; - Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль; - Татварын багц хууль; - Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга; - Барилгын аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай НҮБ-ын 1998 оны 167 дугаар конвенцид нэгдэн орох тухай хууль зэрэг. Б. Хариуцаж боловсруулсан томоохон хуулийн төслүүд: - Газрын багц хууль /нийт 5 төсөл/; - Хот байгуулалтын тухай хууль /төсөл/;

	- <i>Геодезийн тухай хууль /төсөл/;</i> - <i>Бэлчээрийн тухай хууль /төсөл/;</i> - <i>Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;</i> - <i>Ашигт малтмалын тухай хууль /төсөл/ зэрэг.</i> В. Зарим бодлогын баримт бичгүүд, дүрэм, журам: - <i>Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогын баримт бичиг;</i> - <i>Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичиг;</i> - <i>Барилгын тухай хуулийг дагалдан гарах 33 дүрэм, журам;</i> - <i>Ипотекийн санхүүжилтийн ерөнхий журам;</i> - <i>Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам;</i> - <i>Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам;</i> - <i>“150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөр зэрэг.</i> -Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ. -Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө. /Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/
--	--

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>/500-1000 үгэнд багтаана/.</i> Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалд нэр дэвшиж буй иргэнд Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлага тавигддаг эдийн засаг, санхүү, эсхүл хууль зүйн чиглэлээр дээд боловсролын зэрэгтэй байх, төрийн албаны эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан байх, сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй байх зэрэг билээ. Миний хувьд 1993-1997 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалавр, 1997-1999 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн. 1997 онд ажлын гараагаа Улаанбаатар-Эрдэм дээд сургуульд багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж эхлээд, 1999 оноос төрийн албанд орж тасралтгүй ажиллаж ирсэн. Үүнд: 1999 оноос УИХ-ын
------------	---

гишүүний туслах, 2000 оноос УИХ-ын Тамгын газарт Зөвлөх, 2005 оноос Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, 2006 оноос Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөх, 2007 оноос Сангийн яаманд Газрын дарга, 2008 оноос УИХ-ын Тамгын газарт Тамгын газрын нарийн бичгийн дарга /одоогийн нэршлээр Хууль, эрх зүйн асуудал хариуцсан тэргүүн дэд дарга/, 2015 оноос Хөдөлмөрийн яаманд Төрийн нарийн бичгийн дарга, 2015 оны 10 дугаар сараас Барилга, хот байгуулалтын яаманд Төрийн нарийн бичгийн дарга, 2023 оноос Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд Төрийн нарийн бичгийн даргаар тус тус ажилласан туршлагатай. Улсад 26 жил ажилласнаас төр, захиргааны бүх шатны байгууллагад удирдах, гүйцэтгэх, туслах ажил хийж, үүнээс эрхэлсэн болон түүнээс дээш ангиллын албан тушаалтайгаар улс орныхоо эдийн засаг нийгмийн өндөр ач холбогдолтой салбаруудад тасралтгүй 20 жил ажилласан.

Төрийн албан хаагчийн хувьд төдийгүй иргэн хүнийхээ хувьд Монгол төрийн хяналтын тогтолцоог сайжруулж, улмаар төрд итгэх иргэдийн итгэл, үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар олон зүйлийг шат дараатай авч хэрэгжүүлж, улам төгөлдөржүүлэх шаардлагатай гэж үздэг.

Төсвийг иргэд, олон нийтийн татвар, төлбөр, хураамжийн хөрөнгөөс бүрдүүлдэг тул төрийн санхүүгийн удирдлага нийтийн мөнгийг үр ашигтай, үр нөлөөтэй, арвич хямгач байх зарчмаар төлөвлөж, захиран зарцуулж буй эсэх, тэдгээрийг зохицуулж буй хууль, эрх зүйн орчны талаарх үнэн зөв, бодит мэдээллээр хангагдахыг иргэд, олон нийт, холбогдох байгууллага, албан тушаалтан хүсэн хүлээж байдаг. Төрийн санхүүгийн удирдлагын дээрх зарчмыг зөрчсөн тохиолдлыг таслан зогсоож, засан залруулах боломж олгох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх, хохирлыг барагдуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийт, холбогдох байгууллагыг бодит мэдээллээр хангах чиг үүрэг бүхий төрийн тогтолцооны салшгүй бүрдэл хэсэг нь Төрийн аудитын байгууллага юм.

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлснээр төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцлийг төгөлдөржүүлэх, татвар төлөгчдийн бүрдүүлсэн төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд бодитойгоор хүргэх боломж бүрдэх учиртай.

Миний бие төрийн албаны ёс зүй, хариуцлага, хараат бус байх зарчмыг баримталж, төрийн албанд ажиллахдаа ил тод, шударга, хуульд захирагдах зарчмыг хатуу мөрдөж ирсэн. Ерөнхий аудиторын албан тушаал нь улс төрөөс ангид, мэргэжлийн, хараат бус байж гэмээнэ үр дүнтэй ажиллах боломжтой билээ. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг илүү нээлттэй, мэдээлэлд суурилсан, орчин үеийн арга хэрэгслээр дэмжигдсэн болгох нь чухал гэж үздэг. Би энэ чиглэлээр олон улсын шилдэг туршлагыг нутагшуулах замаар төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөх, зарцуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн, үр дүнтэй хяналтыг бодит ажил хэрэг болгох зорилготой. Тодруулбал, Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага, түүний гишүүн орнуудын сайн туршлага, аудитын бодлого, арга зүйн чиг хандлагаас үзэхэд аудитад мэдээллийн технологийн хөгжил дэвшилд суурилсан арга зүйг ашиглах, цахим аудитын тогтолцоо бий болгож хөгжүүлэхийг эрмэлзэх юм.

Гүйцэтгэлийн аудитын үр нөлөөг сайжруулахын тулд тухайн сэдвээр аудит хийх урьдчилсан судалгааны ажилд зарцуулах хугацааг зохистой болгон төрийн аудитын стандартын зарчмыг баримтлан улсын хэмжээнд хэрэгжүүлж буй томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны эрсдэлийг

бууруулсан зардлын хязгаарлалттай, сөрөг үр дагавар багатай, хэрэгжихэд дэмжлэг болохуйц бодит хугацааны чанартай аудит гүйцэтгэхийг чухалчилна.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тулгарч болохуйц нөхцөл байдлыг үнэлж, сайн туршлага, эрсдэлд суурилсан дүн шинжилгээнд үндэслэн, зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд гүйцэтгэх засаглалд зөвлөн туслах үүргээ хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.

Төрийн аудитын байгууллага төрийн хяналтыг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн шийдэлд үндэслэн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тулгарч болохуйц аливаа асуудлаар нөхцөл байдлыг үнэлж, эрсдэлтэй асуудал болон дүн шинжилгээ, нотлох зүйлсэд тулгуурлан, тухайлсан нөхцөл байдалд бодитой үнэлэлт, дүгнэлт өгөхүйц арга хэмжээг аудитын тайлангаар дамжуулан төр, олон нийтэд толилуулдаг.

Энэ бүхнийг хэрэгжүүлэхэд аудитын технологи, арга зүй, горимыг сайжруулах, мэдээллийн цахим тогтолцоог бий болгох, нөгөө талаас иргэд, олон нийтийн санаа бодлыг төрийн хяналтад нээлттэй хүлээн авахад анхаарлаа хандуулна. Орчин үеийн технологид суурилсан хяналтын тогтолцоо бүрдүүлэх санхүүгийн хяналт, аудитын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дата шинжилгээ зэрэг орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ. Төсвийн гүйлгээ, төрийн худалдан авалтыг бодит цаг хугацаанд хянах автомат хяналтын системийг хөгжүүлж, зөрчлийг эрт илрүүлэх, таслан зогсоох боломжийг бүрдүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

Төрийн аудитын байгууллагаас төрийн байгууллагуудыг манлайлах замаар олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн бодит цаг хугацааны болон стратегийн аудитыг гүйцэтгэхийг байнгын зорилт, шалгах зүйлс болгон ажиллахыг эрхэмлэнэ. Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, санал хүсэлтийг шуурхай авч, хамтран ажиллах механизмыг бий болгосноор төрийн аудит нь зөвхөн хяналтын бус, нийгмийн хариуцлага, зөв бодлого төлөвлөлтийг дэмжих гүүр болох учиртай.

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн аудитын тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд төрийн аудитын байгууллага нийтийн эрх ашгийн төлөө иргэдийнхээ амьдралыг сайжруулахад чиглэсэн аудитыг гүйцэтгэн, улс орныхоо нийгэм, эдийн засгийн амьдралд бодит хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Хавсралт:

Холбогдох хуульд заасан шаардлагыг хангасныг нотлох дараах болон бусад баримт бичгийг нэр дэвших тухай хүсэлтэд хавсаргана:

- 1.Төрийн албан хаагчийн анкет;
- 2.Эрх бүхий албан тушаалтнаас нэр дэвшүүлсэн албан бичиг, шийдвэр;
- 3.Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг, лавлагаа;
- 5.Боловсролын зэргийн дипломын хуулбар;
- 6.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;

7.Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т заасан төрийн албаны эрхэлсэн түшмэлээс дээш ангиллын албан тушаалд 10-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг нотлон харуулсан баримт;

8.Энэхүү загварт заасан баримт бичиг;

9.Холбогдох бусад баримт.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Сандаг

Өөрийн нэр: Магнайсүрэн

Гарын үсэг:

Он, сар, өдөр: